Аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын
газрын даргын 2020 оны 09 дугаар сарын 04-ний
өдрийн 45 дугаар тушаалын 1р хавсралт

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН
ГАЗРААС ГАЗРЫН ХАРИЛЦААНЫ МЭРГЭЖИЛТЭН, ГАЗРЫН ДААМЛУУДАД
ЗОХИОН БАЙГУУЛАХ СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР**

Хугацаа	Үйл ажиллагаа
2020 оны 09 дүгээр сарын 04-ний өдөр	
08:30-08:50	Албан хаагчид сургалтын танхимд цугларч, сургалтанд бэлдсэн байх
08:50-09:00	Нээлтийн үйл ажиллагаа / Газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Х.Энхбат /
09:00-10:30	Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийн хаягжуулалт / ГЗБГЗЗГ-н ГЗЗ-н хэлтсийн мэргэжилтэн П.Тэргэл /
10:30-10:45	Цайны завсарлага
10:45-12:15	1:1000-ны масштабтай байр зүйн зургийн жижүүрлэлт / ГЗБГЗЗГ-н ГЗЗ-н хэлтсийн мэргэжилтэн П.Тэргэл /
12:15-13:00	Албан хаагчдын санал хүсэлтийг сонсох, асуултанд хариулах
13:00-14:30	Өдрийн хоол
14:30-15:30	Газрын төлбөрийн ногдуулалт, нэхэмжлэл үүсгэх, анхаарах асуудал / Газрын удирдлагын хэлтсийн дарга Н.Оюунгэрэл /
15:30-15:45	Цайны завсарлага
15:45-16:30	Нутаг дэвсгэрийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хот төлөвлөлтийн асуудал /Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга Ц.Баярмаа/
16:30-17:30	Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг тайлагнах, тайлан мэдээ гаргахад анхаарах асуудал / Хуульч С.Шинэбаяр /
17:30-18:00	Албан хаагчдын санал хүсэлтийг сонсох, асуултанд хариулах
2020 оны 09 дүгээр сарын 05-ны өдөр	
09:00-10:30	Газар зүйн нэрийн тодруулалт, шинэ нэрийн санал хүлээн авах / ГЗБГЗЗГ-н ГЗЗ-н хэлтсийн мэргэжилтэн Д.Ундармаа /
10:30-10:45	Цайны завсарлага
10:45-12:15	Газар зүйн нэрийн зөвлөлийн үйл ажиллагааг зохион байгуулах, шинээр нэр өгөх, өөрчлөх нэрийн саналыг хэлэлцэх, уламжлах / ГЗБГЗЗГ-н ГЗЗ-н хэлтсийн мэргэжилтэн Д.Ундармаа /
12:15-13:00	Албан хаагчдын санал хүсэлтийг сонсох, асуултанд хариулах
13:00-14:30	Өдрийн хоол
14:30-15:30	Түүх, дурсгалт газрын хамгаалалтын бүс тогтоох / ГЗБГЗЗГ-н ГЗЗ-н хэлтсийн мэргэжилтэн Д.Ундармаа /
15:30-15:45	Цайны завсарлага
15:45-17:00	Геодезийн цэг, тэмдэгтийн хайгуул, судалгаа, хадгалалт, хамгаалалт / ГЗБГЗЗГ-н ГЗЗ-н хэлтсийн мэргэжилтэн В.Отгонбаяр /
17:00-17:30	Албан хаагчдын санал хүсэлтийг сонсох, асуултанд хариулах
2020 оны 09 дүгээр сарын 06-ны өдөр	
09:00-10:30	Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим систем ашиглан тухайн жилийн төлөвлөгөө боловсруулах, хэрэгжилтийг тайлагнах / ГЗБГЗЗГ-н ГЗЗ-н хэлтсийн мэргэжилтэн Ц.Ихбаяр /

10:30-10:45	Цайны завсарлага
10:45-12:15	Газрын кадастрын мэдээллийн сангийн цахим системийн үйл ажиллагаа / ГЗБГЗЗГ-н Кадастрын хэлтсийн мэргэжилтэн Э.Чинзолбоо /
12:15-13:00	Албан хаагчдын санал хүсэлтийг сонсох, асуултанд хариулах
13:00-13:30	Дурсгалын зураг татуулах
14:00-15:30	Өдрийн хоол
15:30-16:00	Үдэлтийн арга хэмжээ

—oOo—

Аймгийн ГХБХБГ-ын даргын гур орлон гүйцэтгэгчийн
2020 оны 03 сарын 1-ны өдрийн
тоот тушаалын 2-р хавсралт



Сургалтын, зөвлөгөөний зардал

Д/Д	Зардлын төрөл	Тоо ширхэг	Нийт үнэ
1	Бичиг хэргийн зардал	3 өдөр	200,000.00
2	Сургалтанд оролцогчдын хоол	30*40000	1,200,000.00
3	Цай, кофены зардал	3 өдөр*16*1000	32,000.00
	Нийт дүн	-	1,432,000.00



76

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ТАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
**ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА,
ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 09 сарын 01 өдөр

Дугаар А/56

Дорноговь аймаг, Сайншанд сум

Дүрэм батлах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.4 дэх заалт, Монгол улсын Засгийн газрын 2014 оны 308 дугаар тогтоолоор батлагдсан "Барилгын материалын чанарт тавих лабораторийн хяналтыг өргөжүүлэх хөтөлбөр", "Сорилтын болон шалгалт тохируулгын лабораторийн чадавхид тавих ерөнхий шаардлага /MNS ISO/IEC 17025:2018/ стандарт", Хот байгуулалтын сайдын 2016 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн А/193 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус газрын дэргэдэх Барилгын материалын сорилт, шинжилгээний лабораторийн дүрмийг хавсралтаар баталсугай.

2. Лабораторийн дүрмийг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Барилгын материалын үйлдвэрлэл, лабораторийн асуудал хариуцсан мэргэжилтэн / Ш.Найдансүрэн/-д даалгасугай.

3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан ГХБХБГ-ын даргын 2018 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн А/49 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Х.ЭНХБАТ



ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
**ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА,
ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 09 сарын 01 өдөр

Дугаар 1157

Дорноговь аймаг, Сайнтанд сум

Чанарын гарын авлага батлах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.4 дэх заалт, Монгол улсын Засгийн газрын 2014 оны 308 дугаар тогтоолоор батлагдсан "Барилгын материалын чанарт тавих лабораторийн хяналтыг өргөжүүлэх хөтөлбөр", "Сорилтын болон шалгалт тохируулгын лабораторийн чадавхид тавих ерөнхий шаардлага /MNS ISO/IEC 17025:2018/ стандарт"-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус газрын дэргэдэх Барилгын материалын сорилт, шинжилгээний лабораторийн чанарын гарын авлагыг хавсралтаар баталсугай.

2. Чанарын гарын авлагыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Барилгын материалын үйлдвэрлэл, лабораторийн асуудал хариуцсан мэргэжилтэн / Ш.Найдансүрэн/-д даалгасугай.

3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан ГХБХБГ-ын даргын 2018 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн А/49 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Х.ЭНХБАТ



18

ДӨРНОГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ХӨРӨГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
**ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА,
ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 09 сарын 04 өдөр

Дугаар 8/58

Дорноговь аймаг, Сайншанд сум

Журам батлах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.4 дэх заалт, Монгол улсын Засгийн газрын 2014 оны 308 дугаар тогтоолоор батлагдсан "Барилгын материалын чанарт тавих лабораторийн хяналтыг өргөжүүлэх хөтөлбөр", "Сорилтын болон шалгалт тохируулгын лабораторийн чадавхид тавих ерөнхий шаардлага / MNS ISO/IEC 17025:2018/ стандарт"-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус газрын дэргэдэх Барилгын материалын сорилт, шинжилгээний лабораторийн Ажилтны журмыг нэгдүгээр хавсралтаар, Тоног төхөөрөмж ашиглалтын журмыг хоёрдугаар хавсралтаар, Хүсэлт, гэрээнд дүн шинжилгээ хийх журмыг гуравдугаар хавсралтаар, Сорилтын зүйлтэй харьцах журмыг дөрөвдүгээр хавсралтаар, Хэмжлийн эргэлзээг тооцох журмыг тавдугаар хавсралтаар, Чанарын хяналтын журмыг зургаадугаар хавсралтаар, Гомдол маргаан шийдвэрлэх журмыг долдугаар хавсралтаар, Үл тохирох ажлын журмыг наймдугаар хавсралтаар, Лабораторийн журмыг есдүгээр хавсралтаар, Дотоод аудит хийх журмыг аравдугаар хавсралтаар, Менежментийн дүн шинжилгээний журмыг арван нэгдүгээр хавсралтаар, Бүртгэлийн хяналтын журмыг арван хоёрдугаар хавсралтаар, Шударга байдал, нууцыг хадгалах журмыг арван гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Дээрх журмуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Барилгын материалын үйлдвэрлэл, лабораторийн асуудал хариуцсан мэргэжилтэн / Ш.Найдансүрэн/-д даалгасугай.

3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан ГХБХБГ-ын даргын 2018 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн А/49 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Х.ЭНХБАТ



АЖИЛТНЫ ЖУРАМ

1. Зорилго

Энэхүү журмаар Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /ГХБХБГ/-ын Барилгын материалын лабораторийн ажилтны /цаашид ажилтан гэх/ ур чадварт тавих шаардлагыг тодорхойлох, сонгох, сургах, хяналт тавих, эрх олгох, ур чадварт хяналт үнэлгээ хийх зэрэг үйл ажиллагааг зохицуулна.

2. Хамрах хүрээ

Энэхүү журам нь ГХБХБГ-ын Барилгын материалын лабораторийн ажилтнуудад хамаарна.

3. Үүрэг хариуцлага

- 3.1. ГХБХБГ-ын дарга нь дараах асуудлыг хариуцна:
 - 3.1.1. Ажилтнуудыг томилох, чөлөөлөх
 - 3.1.2. Ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтыг хянаж, ур чадварт тавигдах шаардлагыг хянаж, баталгаажуулах
 - 3.1.3. Ажилтнуудыг мэргэших сургалтанд хамрагдах нөхцөл боломжоор хангах
- 3.2. Лабораторийн эрхлэгч нь дараах асуудлыг хариуцна:
 - 3.2.1. Ажилтны ур чадварт тавих шаардлагыг тодорхойлох
 - 3.2.2. Ажилтны сургалтын хэрэгцээ шаардлагыг тодорхойлох, сургалтын төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх, дотоод сургалтыг үр дүнтэй зохион байгуулах, тайлагнах
 - 3.2.3. Ажилтны өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавих, ур чадварт хяналт үнэлгээ хийх, тайлагнах
- 3.3. ГХБХБГ-ын хуулийн асуудал хариуцсан мэргэжилтэн дараах асуудлыг хариуцна:
 - 3.3.1. Ажилтны хүний нөөцийн судалгаа, хувийн хэргийн баяжилт хөтлөлтийг хариуцах
 - 3.3.2. Ажилтныг орон тоо зарлагдсан тохиолдолд сонгон шалгаруулах үйл ажиллагааг зохион байгуулах

4. Лабораторийн ажилтны ур чадварт тавих шаардлага

Лабораторийн эрхлэгч, шинжээчид тавих шаардлагыг ГХБХБГ-ын даргын тушаалаар баталсан ажлын байрны тодорхойлолтод тусгаж өгнө.

5. Ажилтныг сонгох

- 5.1. Лабораторийн ажилтныг сонгон шалгаруулах үйл ажиллагааг ГХБХБГ-ын хуулийн асуудал хариуцсан мэргэжилтэн зохион байгуулна.
- 5.2. Лабораторийн ажилтны сул орон тоог хэвлэл мэдээллийн хэрэгслэл, байгууллагын мэдээллийн хэрэгслэлээр олон нийтэд зарлана.

- 5.3. Шинээр ажилд орох иргэний ажилд орох өргөдлийг үндэслэн ГХБХБГ-ын хуулийн асуудал хариуцсан мэргэжилтэн хүлээн авч бүртгэн, баримт бичигт хяналт хийн, ГХБХБГ-ын даргад танилцуулж, ажлын байрны тодорхойлолтод заагдсан шаардлагуудыг хангасан иргэдээс сонгон шалгаруулна.
- 5.4. Лабораторийн эрхлэгчийг сонгон шалгаруулах үйл ажиллагааг ГХБХБГ-ын дарга, БХБХ-ийн дарга, хуулийн асуудал хариуцсан мэргэжилтний бүрэлдэхүүнтэйгээр, лабораторийн шинжээчийг сонгон шалгаруулах үйл ажиллагааг ГХБХБГ-ын дарга, лабораторийн эрхлэгч, хуулийн асуудал хариуцсан мэргэжилтний бүрэлдэхүүнтэйгээр тус тус зохион байгуулна.
- 5.5. Ажилтныг сонгон шалгаруулалтанд орох үндэслэл нь:
- 5.5.1. Ажлын байрны тодорхойлолтод заагдсан шаардлагыг хангасан байх,
- 5.5.2. Ажилтны бүрдүүлсэн баримт бичиг үнэн зөв байх,
- 5.6 Ажилтны сонгон шалгаруулалтын дараалал нь :
- 5.6.1 Ажил мэргэжил болон холбогдох хууль тогтоомжтой холбоотой тестээр шалгалт авах
- 5.6.2 Тестийн шалгалтанд тэнцсэн хүмүүсээс төрийн албаны ёс зүй, ажлын байрны тодорхойлолтонд нийцэх ур чадварын талаар комиссын бүрэлдэхүүн ярилцлага авах

6. Ажилтныг сургах

- 6.1. Лабораторийн эрхлэгч нь ажилтнуудыг сургах сургалтын төлөвлөгөөг 2 жил тутам хугацаатайгаар боловсруулж, ГХБХБГ-ын даргаар батлуулан хэрэгжүүлнэ.
- Сургалтын хэлбэр:
- Дотоод сургалт /Чанарын гарын авлага, Лабораторийн дүрэм, Менежментийн тогтолцооны журмууд, САЗ, Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрэм, сорилт шинжилгээний батлагдсан арга аргачлал, ажлын байранд сургаж, дадлагажуулах зэрэг/
 - Мэргэжил, ур чадвар дээшлүүлэх сургалт
 - Менежментийн тогтолцооны сургалт
 - Шинэ арга, аргачлал эзэмшүүлэх дагалдан сургалт
 - Гадаад орон дахь мэргэжил дээшлүүлэх сургалт
 - Бусад
- 6.2. Сургалтын төлөвлөгөөнд ажилтнуудыг лабораторийн менежментийн тогтолцоонд сургах, сорилт шинжилгээний арга аргачлалд сургах, дагалдуулан сургах зэрэг асуудлуудыг тусгасан байна.
- 6.3. Лабораторийн эрхлэгч нь шинэ ажилтанд дотоод сургалтыг зохион байгуулж, шалгалт авна.
- 6.4. Лаборатори нь ажилтнуудын сургалтын бүртгэлтэй байх бөгөөд бүртгэлийг лабораторийн эрхлэгч хөтөлнө. /Маягт 01/

7. Ажилтанд хяналт тавих

- 7.1. Лаборатори нь ажилтанд тавих дотоод хяналтын төлөвлөгөөтэй байна.
- 7.2. Лабораторийн эрхлэгч нь дотоод хяналтын төлөвлөгөөний дагуу ажилтанд хяналт тавьж ажиллана. Зэрэгцээ шинжилгээ, үл мэдэгдэх дээжид шинжилгээ хийх зэргээр 4

сар тутамд ажилтнуудын ур чадварт хяналт тавьж, бүртгэл хөтлөж ажиллана. /Маягт 02/ 89

8. Ажилтанд эрх олгох

- 8.1. ГХБХБГ-ын дарга нь лабораторийн ажилтанд тушаалаар үйл ажиллагаа хэрэгжүүлэхтэй холбоотой эрх олгоно.
- 8.2. Лабораторийн сорилтын тайланг баталгаажуулах эрхийг ГХБХБГ-ын даргын тушаал шийдвэрээр лабораторийн эрхлэгч, шинжээч нарт олгоно.

9. Ажилтны ур чадварт хяналт үнэлгээ хийх

- 9.1. Лабораторийн эрхлэгч нь ажилтнуудад батлагдсан төлөвлөгөөний дагуу лаборатори хоорондын харьцуулалт, ур чадварын сорилт, лабораторийн дотоод хяналтыг тогтмол хийж ажилтны ур чадварт байнгын хяналт тавьж ажиллана.
- 9.2. Ажилтны ур чадварт хийсэн хяналт шалгалтанд лабораторийн эрхлэгч дүн шинжилгээг хийж шаардлагатай арга хэмжээг авч ажиллана.

10. Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах

- 10.1. Энэхүү журамд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа ГХБХБГ-ын даргын тушаалаар шийдвэрлэнэ.
- 10.2. Журамд орсон нэмэлт, өөрчлөлтийг лабораторийн эрхлэгч бүртгэнэ. /Маягт 03/

АЖИЛТНЫ СУРГАЛТЫН БҮРТГЭЛ


№	Сургалтын нэр	Гэрчилгээний дугаар	Огноо	Зохион байгуулсан газрын нэр	Сургалтанд хамрагдсан ажилтны албан тушаал, нэр	Сургалтын агуулга

АЖИЛТНУУДЫН УР ЧАДВАРЫН ХЯНАЛТЫН БҮРТГЭЛ

№	Шинжилгээний нэр төрөл	Гүйцэтгэсэн огноо	Гүйцэтгэсэн шинжээчийн нэр	Гүйцэтгэсэн шинжээчийн гарын үсэг	Хянасан эрхлэгчийн гарын үсэг	Тайлбар

ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛСАН БҮРТГЭЛ

д/д	Өөрчлөлтийн дугаар	Хуудасны дугаар	Өөрчлөлт оруулсан шалтгаан



ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ АШИГЛАЛТЫН ЖУРАМ

1. Зорилго

Энэхүү журмаар барилгын материалын лабораторийн тоног төхөөрөмжийн зохистой ажиллагааг хангах, бохирдож элэгдэхээс нь сэргийлэх, тэдгээртэй харьцах, тээвэрлэх, хадгалах, ашиглах, төлөвлөгөөт засвар үйлчилгээ хийх асуудлыг зохицуулна.

2. Хамрах хүрээ

Энэхүү журам нь Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /ГХБХБГ/-ын Барилгын материалын лабораторийн тоног төхөөрөмж ашиглахтай холбоотой үйл ажиллагаанд хамаарна.

3. Үүрэг хариуцлага

3.1. Лабораторийн эрхлэгч нь дараах үүргийг хэрэгжүүлнэ:

- Тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангах, бодлого, журмын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллах
- Тоног төхөөрөмжийн шалгалт тохируулгын хөтөлбөрийг 2 жилээр төлөвлөж, ГХБХБГ-ын даргаар батлуулан хэрэгжүүлж ажиллах

3.2. Лабораторийн шинжээч буюу техникийн менежер нь дараах үүргийг хэрэгжүүлнэ:

- Тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангах, бохирдож элэгдэхээс сэргийлэх, тээвэрлэх, хадгалах, ашиглах, төлөвлөгөөт засвар үйлчилгээ хийх үйл ажиллагааг хариуцах
- Тоног төхөөрөмжийн ажиллах зааврыг чанд мөрдөж ажиллах
- Тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээний төлөвлөгөөг 2 жилээр төлөвлөж, лабораторийн эрхлэгчээр батлуулан, хэрэгжүүлж ажиллах
- Тоног төхөөрөмжийн стандарт ажиллагааны заавар /CA3/-ыг боловсруулж, ГХБХБГ-ын даргын тушаалаар батлуулах
- Тоног төхөөрөмжийн бүртгэл, засвар үйлчилгээний бүртгэл, шалгалт тохируулга хийсэн бүртгэлийг тус тус хөтлөх /Маягт №01, 02, 03/, хадгалах
- Тоног төхөөрөмжийн техник ашиглалтын паспортыг хөтлөх, хадгалах

4. Тоног төхөөрөмжийн ашиглалт

4.1. Лаборатори нь тоног төхөөрөмжийг бүртгэн, засвар үйлчилгээ хийж, байнгын хяналтанд байлгана.

4.2. Техникийн менежер нь сорилт шинжилгээний ажил эхлэхээс өмнө тоног төхөөрөмжийн тоос шороог цэвэрлэх, бүрэн бүтэн, аюулгүй байдлыг шалгаж, хэвийн ажиллагааг хангана.

4.3. Сорилт шинжилгээний ажил дууссаны дараа тоног төхөөрөмжийг унтрааж, цахилгаан хүчдэлээс салгасны дараа тоос шороог цэвэрлэнэ.

4.4. Лаборатори нь өөрийн байнгын хяналтанд байдаггүй тоног төхөөрөмжийг ашиглах тохиолдолд тус тоног төхөөрөмжийн ажиллах зааврыг судлах, шалгалт тохируулга хийгдсэн эсэхийг тодруулах, аюулгүй ажиллагааг хангах зэрэг шаардлагуудыг хангуулсан байна.

5. Тоног төхөөрөмжийн шалгалт тохируулга

- 5.1. Лаборатори нь тоног төхөөрөмжид шалгалт тохируулга хийх хөтөлбөр, төлөвлөгөөтэй байх ба лабораторийн эрхлэгч хэрэгжүүлэн ажиллана.
- 5.2. Лабораторийн эрхлэгч нь тоног төхөөрөмжид төлөвлөгөөний дагуу болон хэмжлийн нарийвчлал нь тайлагнасан үр дүнгийн үнэн бодит нөлөө үзүүлж байгаа тохиолдолд шалгалт тохируулгыг чадавхитай лабораториор гэрээний үндсэн дээр хийлгэнэ.
- 5.3. Лабораторид шинэ тоног төхөөрөмжийг байршуулах болон засварлаад буцаад ажиллагаанд оруулахын өмнө чадавхитай лабораторид гэрээний үндсэн дээр шалгалт тохируулгыг хийлгэнэ.
- 5.4. Лабораторийн хэмжилд ашиглаж байгаа тоног төхөөрөмжийн шалгалт тохируулга нь хэмжлийн эргэлзээ тооцсон байна.
- 5.5. Тоног төхөөрөмжийн шалгалт тохируулгын гэрчилгээг тухайн тоног төхөөрөмж, багаж хэрэгслэлийн дэргэд байршуулна.
- 5.6. Техникийн менежер нь төлөвлөгөөний дагуу холбогдох тоног төхөөрөмжид дотоод шалгалтыг хийж гүйцэтгэнэ.
- 5.7. Техникийн менежер нь тоног төхөөрөмж, багаж хэрэгслэлийн шалгалт тохируулгыг бүртгэнэ.

6. Засвар үйлчилгээ

- 6.1. Лабораторийн тоног төхөөрөмжийг засварлах, шинэчлэх зардлыг байгууллагын холбогдох зардлаас гаргах ба ГХБХБГ-ын даргын тушаалаар шийдвэрлэнэ.
- 6.2. Техникийн менежер нь тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээний төлөвлөгөөг хэрэгжүүлэн, хэрэгжилтийг лабораторийн эрхлэгчид тайлагнана.
- 6.3. Техникийн менежер нь лабораторийн үйл ажиллагааг саадгүй явуулах нөхцөлийг ханган тоног төхөөрөмжийг хариуцан эвдрэл доголдол гарсан даруйд тоног төхөөрөмжийг зогсоож лабораторийн эрхлэгчид шуурхай мэдэгдэж, асуудлыг шийдвэрлүүлнэ.
- 6.4. Тоног төхөөрөмж эвдэрсэн тохиолдолд техникийн менежер нь тухайн тоног төхөөрөмжид зохих тэмдэглэгээг хийх, учир шалтгааныг судлан тогтоох, засварлуулах арга хэмжээг авна.
- 6.5. Тоног төхөөрөмжийн эвдрэлийг засварласны дараа эвдрэл гарсан шалтгаанаас хамааран лабораторийн эрхлэгч тухайн тоног төхөөрөмжид шалгалт тохируулга хийлгэх шаардлагатай эсэхийг судлан шийдвэрлэнэ. Тоног төхөөрөмжид шаардлагатай шалгалт тохируулга хийсний дараа сорилт шинжилгээнд ашиглана.
- 6.6. Техникийн менежер нь засвар үйлчилгээнд шаардлагатай эд зүйлсийг лабораторийн эрхлэгчээр дамжуулан ГХБХБГ-ын шаардах хуудсаар авна.
- 6.7. Техникийн менежер нь засвар үйлчилгээний мэдээллийг засвар үйлчилгээний бүртгэлд тухай бүр бүртгэнэ.

7. Тоног төхөөрөмжийн бүртгэл

- 7.1. Лабораторийн тоног төхөөрөмж нь ГХБХБГ-ын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй байна.
- 7.2. Лабораторийн тоног төхөөрөмж нь техникийн шаардлагын дагуу суурилагдсан, шалгалт тохируулга хийгдсэн, техник ашиглалтын паспорт хөтлөгдсөн байна.
- 7.3. Техникийн менежер нь шинэ тоног төхөөрөмжийг хүлээн авч бүртгэх, тоног төхөөрөмжийн бүртгэлийг хөтлөх, техник ашиглалтын паспортыг хөтлөх, хадгалах асуудлыг хариуцна.

8. Тоног төхөөрөмжийн хадгалалт, хамгаалалт

- 8.1. Лабораторийн эрхлэгч нь тоног төхөөрөмжийг техникийн зааварт заасан нөхцлийг бүрдүүлэн хадгалах ба зөөж тээвэрлэхдээ шаардлагатай арга хэмжээг авна.
- 8.2. ГХБХБГ-ын даргын албан ёсны зөвшөөрөлгүйгээр тоног төхөөрөмжийг ажлын байрнаас гаргахыг хориглоно.

8.3. Лабораторийн эрхлэгч нь шаардлагатай тохиолдолд тоног төхөөрөмжийг тохируулахаас хамгаалан лацдах арга хэмжээг авч болно.

9. Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах

9.1. Энэхүү журамд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа ГХБХБГ-ын даргын тушаалаар шийдвэрлэнэ.

9.2. Журамд орсон нэмэлт, өөрчлөлтийг лабораторийн эрхлэгч бүртгэнэ. /Маягт 04/

---000---

Маягт 01

ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН БҮРТГЭЛ

№	Тоног төхөөрөмжийн нэр	Хүчин чадал	Хийц /Загвар/ модель №	Үйлдвэрлэсэн огноо	Үйлдвэрлэсэн газар	Серийн дугаар

Маягт 02

ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИД ХИЙСЭН ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БҮРТГЭЛ

№	Тоног төхөөрөмжийн нэр	Засвар үйлчилгээ хийсэн огноо, цаг	Засвар үйлчилгээ хийсэн байдал	Засвар үйлчилгээ хийсэн хүний албан тушаал	Засвар үйлчилгээ хийсэн хүний нэр, гарын үсэг

Маягт 03

ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИД ХИЙСЭН ШАЛГАЛТ ТОХИРУУЛГЫН БҮРТГЭЛ

№	Тоног төхөөрөмжийн нэр	Шалгалт тохируулга хийсэн огноо	Шалгалт тохируулга хийсэн байгууллагын нэр, хаяг	Шалгалт тохируулга хийсэн хүний нэр, албан тушаал	Хүлээн авсан ажилтны нэр, албан тушаал

Маягт 04

ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛСАН БҮРТГЭЛ

д/д	Өөрчлөлтийн дугаар	Хуудасны дугаар	Өөрчлөлт оруулсан шалтгаан



87

ХҮСЭЛТ, ГЭРЭЭНД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ ЖУРАМ

1. Зорилго

Энэхүү журмаар барилгын материалын лабораторид хэрэглэгчээс ирүүлсэн хүсэлт, гэрээнд дүн шинжилгээ хийх үйл ажиллагааг зохицуулна.

2. Хамрах хүрээ

Барилгын материалын лабораторид хэрэгжиж буй хүсэлт, гэрээний асуудлууд хамаарна.

3. Үүрэг, хариуцлага

- 3.1. Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга нь хэрэглэгчтэй байгуулсан гэрээг баталгаажуулах, хэрэгжилтэд хяналт тавих, аливаа гажилтын талаар хэрэглэгчид мэдэгдэх зэрэг асуудлыг хариуцна.
- 3.2. Лабораторийн эрхлэгч нь хүсэлт, гэрээнд дүн шинжилгээ хийх, хэрэглэгчтэй гэрээ байгуулах, хэрэглэгчийг шаардлагатай мэдээллээр хангах, харьцах, дүн шинжилгээний тайлан гаргах, хурлын тэмдэглэл хөтөлж, хадгалах зэрэг асуудлыг хариуцна.
- 3.3. Хүсэлт, гэрээний дүн шинжилгээтэй холбоотой асуудалд аль буруутай тал хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ.
- 3.4. Лабораторийн эрхлэгч нь гэрээнээс зөрсөн аливаа гажилтын талаар хэрэглэгчид мэдэгдэх ба мэдээлэхдээ ГХБХБГ-ын даргын албан бичгээр хандана.

4. Үйл ажиллагаа

- 4.1. Лаборатори нь хэрэглэгчийн шаардлагыг хангасан сорилтын арга, аргачлал, тоног төхөөрөмжтэй байна.
- 4.2. Лабораторийн эрхлэгч нь сорилт шинжилгээг эхлэхийн өмнө хэрэглэгчийн ирүүлсэн хүсэлтийг хүлээн авч дараах асуудлыг итгэмжлэлийн хүрээний тодорхойлолтод хамаарах эсэх, хэрэглэгчийн тавьсан шаардлагыг хангасан сорилтын арга аргачлалтай эсэх, тоног төхөөрөмжтэй эсэх зэргийг судлан тодорхойлж, хүсэлтийн хоорондох зөрүүтэй асуудлыг шийдвэрлэнэ. Лаборатори нь хүсэлт, гэрээнд заасан ажлыг гүйцэтгэхэд зайлшгүй шаардлага бүхий техник, боловсон хүчин болон мэдээллийн бодит нөөц боломж, ур чадвар, дадлага туршлагыг тооцож тодорхойлно.
- 4.3. Лаборатори нь сорилт шинжилгээг гүйцэтгэхдээ хавсран гүйцэтгэгч авах тохиолдолд хэрэглэгчтэй зөвшилцөж, албан ёсоор зөвшөөрлийг авсан байна.
- 4.4. Хэрэглэгчийн эрэлт шаардлагыг хангасан сорилтын тохирох аргыг сонгож сорилтын ажлыг эхлүүлнэ.
- 4.5. Хэрэглэгчийн санал болгосон арга нь тохиромжгүй буюу хуучирсан гэж үзсэн тохиолдолд энэ тухай лабораторийн эрхлэгч хэрэглэгчид мэдэгдэж, тэмдэглэл үйлдэнэ.

- 4.6. Лабораторийн эрхлэгч нь олон дахин хүсэлт ирүүлдэг хэрэглэгчтэй сорилтын ажил гүйцэтгэх гэрээг байгуулахаар гэрээний нөхцөл, шаардлагыг хэрэглэгчид танилцуулна.
- 4.7. Хэрэглэгч гэрээний нөхцөл, шаардлагыг хүлээн зөвшөөрсний дараа гэрээг 2 хувь үйлдэх ба нэг талаас ГХБХБГ-ын дарга, нөгөө талаас хэрэглэгч байгууллагын удирдлага тус тус баталгаажуулна.
- 4.8. Хэрэв ажил эхэлсний дараа гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах хэрэгтэй бол лабораторийн эрхлэгч нь гэрээнд мөн дахин дүн шинжилгээ хийж, нэмэлт өөрчлөлт бүрийг ГХБХБГ-ын дарга болон лабораторийн шинжээчид мэдээлнэ.
- 4.9. Лабораторийн эрхлэгч нь аливаа чухал өөрчлөлтийг оролцуулан дүн шинжилгээний тайланг хөтөлнө. Хэрэглэгчийн шаардлагын талаархи хэрэглэгчтэй хийсэн хэлэлцүүлгийн тэмдэглэл, гэрээний хүчинтэй хугацаанд хийсэн ажлын үр дүнгийн бүртгэлийг хадгална.
- 4.10. Шинэ, иж бүрэн, илүү өндөр түвшний сорилтыг хийж гүйцэтгэх үед илүү, нарийн дэлгэрэнгүй бүртгэл, тэмдэглэлийг хөтөлж хадгална.
- 4.11. Хэрэглэгчтэй байгуулсан гэрээний биелэлтийг хянах, дүн шинжилгээ нь ажил хэрэгч, үр нөлөөтэй байдлаар хийгдэх ба дүн шинжилгээг хийхдээ лаборатори хоорондын харьцуулалт, стандарт сорьц дээжийг ашиглан хэмжилтийн тодорхой бус байдал, илрэх хязгаар, үнэмшлийн хязгаарыг тогтооно.
- 4.12. Лаборатори нь хэрэглэгчийн хүсэлт шаардлагыг хүлээн авах, хэрэглэгчид өөрт нь хамаарах лабораторийн үйл ажиллагааг биечлэн үзэх зорилгоор лабораторийн зохих хэсэгт нэвтрэн орох боломж олгох зэргээр хамтран ажиллана.
- 4.13. Лабораторийн эрхлэгч дүн шинжилгээний тайланг хөтлөх ба гэрээний хүчинтэй хугацаанд хийсэн лабораторийн ажлын үр дүн, хэрэглэгчийн шаардлагын талаархи хэрэглэгчтэй хийсэн тэмдэглэлийг хөтөлж хадгална.
- 4.14. Дүн шинжилгээнд лабораторийн хавсран гүйцэтгэдэг ажлуудыг хамруулна.
- 4.15. Хүсэлт, гэрээний бүртгэлийг лабораторийн эрхлэгч хөтөлнө. /Маягт 01/
- 4.16. Гэрээ байгуулсан харилцагч тус бүрийн талаарх дэлгэрэнгүй бүртгэлийг хөтөлж, хяналт таьж ажиллах. /Маягт №02/

5. Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах

- 5.1. Энэхүү журамд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа ГХБХБГ-ын даргын тушаалаар шийдвэрлэнэ.
- 5.2. Журамд орсон нэмэлт, өөрчлөлтийг лабораторийн эрхлэгч бүртгэнэ. /Маягт 03/

ХҮСЭЛТ, ГЭРЭЭНИЙ БҮРТГЭЛ

№	Гэрээ байгуулсан хэрэглэгчийн нэр	Гэрээний дугаар	Огноо	Хүсэлт болон гэрээт ажлын мэдээлэл	Бүртгэсэн ажилтны нэр, гарын үсэг

Маягт 02

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ХАРИЛЦАГЧИЙН ТАЛААРХ ДЭЛГЭРЭНГҮЙ БҮРТГЭЛ

Гэрээний дугаар:

Гэрээ байгуулсан харилцагчийн нэр:

Гүйцэтгэсэн төслийн ажлын нэр, хаяг:

Д/д	Дээж өгсөн огноо	Дээжийн код	Маргаан гарсан эсэх	Төлбөр төлсөн эсэх	Бүртгэсэн ажилтны нэр, гарын үсэг

Маягт 03

ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛСАН БҮРТГЭЛ

д/д	Өөрчлөлтийн дугаар	Хуудасны дугаар	Өөрчлөлт оруулсан шалтгаан



СОРИЛТЫН ЗҮЙЛТЭЙ ХАРЬЦАХ ЖУРАМ

1. Зорилго

Энэхүү журмаар Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /ГХБХБГ/-ын Барилгын материалын лабораторийн сорилтын зүйлийг хүлээн авах, харьцах, хадгалах, устгах, буцаан олгох үйл ажиллагааг зохицуулна.

2. Хамрах хүрээ

Энэхүү журам нь ГХБХБГ-ын Барилгын материалын лабораторийн сорилтын зүйл /дээж/-тэй харьцах үйл ажиллагаанд хамаарна.

3. Үүрэг хариуцлага

3.1. Лабораторийн эрхлэгч нь дараах үүргийг хэрэгжүүлнэ:

- Сорилтын зүйлийг сорилт шинжилгээнд хамруулах, хяналт тавих
- Сорилтын зүйлд батлагдсан арга аргачлалын дагуу сорилт шинжилгээг хийх, шинжилгээний стандарт ажиллагааны заавар /САЗ/ боловсруулж, батлуулах
- Сорилтын зүйлийг хүлээн авч бүртгэх /Маягт 01/
- Сорилтын зүйлийг хадгалах орчин нөхцөлийг бүрдүүлэх
- Сорилтын зүйлийг устгах асуудлыг шийдвэрлэх

3.2. Лабораторийн шинжээч нь дараах үүргийг хэрэгжүүлнэ:

- Сорилтын зүйлд батлагдсан арга аргачлалын дагуу сорилт шинжилгээг хийх
- Сорилтын зүйлтэй харьцахдаа хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг бүрэн хангаж ажиллах, ажлын хувцас, амны хаалт, бээлий зэргийг хэрэглэх
- Сорилтын зүйлийг хадгалах, хамгаалах
- Сорилтын зүйлийг устгах, бүртгэх /Маягт 02/

4. Сорилтын зүйлийг хүлээн авах

4.1. Лабораторийн шинжээч хэрэглэгчээс ирүүлсэн сорилтын зүйлийн талаар эрхлэгчид тухай бүр дэлгэрэнгүй мэдээлнэ.

4.2. Шинжээч сорилтын зүйлд сорилт шинжилгээг гүйцэтгэнэ.

5. Сорилтын зүйлтэй харьцах

5.1. Сорилт шинжилгээг гүйцэтгэхэд тохирох эсэх нь эргэлзээтэй, шаардлагыг хангахгүй тохиолдолд лабораторийн эрхлэгч нь хэрэглэгчтэй зөвлөн, тэр тухайгаа тэмдэглэнэ. Тодорхойлсон нөхцлөөс сорилтын зүйл нь гажсан талаар мэдсэн

- хэрэглэгчийн хүсэлтээр сорилтыг гүйцэтгэсэн тохиолдолд тухайн гажилт нь үр дүнд нөлөөлж болох талаар сорилтын тайланд тусгана.
- 5.2. Лаборатори нь сорилт шинжилгээг батлагдсан арга стандарт ажлын зааварчилгааны дагуу гүйцэтгэнэ.
 - 5.3. Сорилтын зүйлийг бохирдуулах, гэмтээх мөн хаяг шошго солигдохоос сэргийлж шинжээчээс өөр хүн сорилтын зүйлд хүрэхийг хориглоно.
 - 5.4. Лабораторийн эрхлэгч нь дээжийг хооронд нь солигдохоос сэргийлж кодлох ба кодыг тухайн дээжийн уут савны гадна талд эсвэл гадаргууд арилдаггүй зүйлээр тэмдэглэнэ. Сорилт шинжилгээ хийж дууссаны дараа тэмдэглэгээг арилгахгүйгээр дээж хадгалах өрөөнд хадгална.

6. Сорилтын зүйлийг хадгалах

- 6.1. Лаборатори нь сорилт шинжилгээг хийж гүйцэтгэсний дараа сорилтын зүйлийг дээж хадгалах өрөөнд тухайн жилд нь хадгалах ба шаардлагатай тохиолдолд тухайн объектыг ашиглалтанд ортолх хүртэл хугацаанд хадгална.
- 6.2. Дээж хадгалах өрөө нь ус чийгнээс тусгаарлагдсан зориулалтын өрөө байна.

7. Сорилтын зүйлийг устгах болон буцаан олгох

- 7.1. Сорилтын зүйлийг тодорхой хугацаанд хадгалсны дараа лабораторийн эрхлэгчийн зөвшөөрлөөр шинжээч устгаж, дээж устгалын бүртгэлд бүртгэнэ.
- 7.2. Хэрэглэгчийн албан хүсэлтийг үндэслэн лабораторийн эрхлэгч сорилтын зүйлийг буцаан олгох эсэх асуудлыг шийдвэрлэнэ.

8. Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах

- 8.1. Энэхүү журамд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа ГХБХБГ-ын даргын тушаалаар шийдвэрлэнэ.
- 8.2. Журамд орсон нэмэлт, өөрчлөлтийг лабораторийн эрхлэгч бүртгэнэ./Маягт 03/

92
Маягт 01

ДЭЭЖ ХҮЛЭЭН АВАХ БҮРТГЭЛ

№	Огноо	Цаг, минут	Дээж ируулсан хэрэглэгч- ийн нэр	Харил цах утас	Дээжийн нэр, тоо хэмжээ	Дээжийн орд газар	Объектын нэр, байршил	Дээж хүлээлгэн өгсөн хүний гарын үсэг	Дээж хүлээн авсан хүний гарын үсэг	Дээ жийн код

Маягт 02


ДЭЭЖ УСТГАЛЫН БҮРТГЭЛ

№	Дээжийн код	Дээжийн нэр, тоо хэмжээ	Шинжилгээ хийж дууссан огноо	Хадгалсан хугацаа	Устгасан огноо	Дээж устгасан шинжээчийн нэр, гарын үсэг

Маягт 03

ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛСАН БҮРТГЭЛ

д/д	Өөрчлөлтийн дугаар	Хуудасны дугаар	Өөрчлөлт оруулсан шалтгаан



ХЭМЖЛИЙН ЭРГЭЛЗЭЭ ТООЦОХ ЖУРАМ

1. Зорилго

Энэхүү журмаар Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /ГХБХБГ/-ын Барилгын материалын лабораторийн шинжилгээний үр дүнг илүү нарийвчлалтай гаргах зорилгоор хэмжлийн эргэлзээ тооцох асуудлыг зохицуулна.

2. Хамрах хүрээ

Энэхүү журам нь Барилгын материалын лабораторийн итгэмжлэлийн хүрээний тодорхойлолтонд багтсан материал, түүхий эдүүдийн сорилтын үр дүнд хэмжлийн эргэлзээг тооцоход хамаарна.

3. Үүрэг хариуцлага

- 3.1. Лабораторийн эрхлэгч нь дараах үүргийг хэрэгжүүлнэ:
 - Сорилтын үр дүнд хэмжлийн эргэлзээг тооцох нөхцөлийг бүрдүүлэх
 - Сорилтын үр дүнд тооцсон хэмжлийн эргэлзээг хянаж, шалгах
 - Сорилтын үр дүнд нөлөөлөх багаж, тоног төхөөрөмжүүдэд шалгалт тохируулгыг тухай бүр хийлгэх
- 3.2. Лабораторийн шинжээч нь дараах үүргийг хэрэгжүүлнэ:
 - Сорилт шинжилгээний үр дүнд хэмжлийн эргэлзээ тооцох
 - Хэмжлийн эргэлзээ тооцсон бүртгэл хөтлөх, хадгалах

4. Үйл ажиллагаа

- 4.1. Лаборатори нь бүх сорилт шинжилгээний хэмжлийн эргэлзээний бүрэлдэхүүн хэсгүүдийг тодорхойлно.
- 4.2. Хэмжлийн эргэлзээний бүрэлдэхүүн хэсгүүдийг сорилт шинжилгээ тус бүр дээр тодорхойлсны дагуу хэмжлийн эргэлзээг тооцоходоо бүрэлдэхүүн хэсгүүдийг тооцоондоо авна.
- 4.3. Лабораторит хийгдэж байгаа сорилтын үр дүнг боловсруулахдаа багаж, тоног төхөөрөмжийн шалгалт тохируулгын гэрчилгээн дээрх өргөтгөсөн эргэлзээний утгыг ашиглаж хэмжлийн эргэлзээг тооцно.
- 4.4. Хэмжлийн эргэлзээний тооцоог шинжээч гүйцэтгэж анхан шатны баримт бичгийг цаасаар болон файлаар хадгална.
- 4.5. Лаборатори нь хэмжлийн эргэлзээг сорилт шинжилгээний тайлан бүрт тооцохгүй, харин тухайн жилд 2-оос доошгүй төрөлд тооцож хадгална.
- 4.6. Лабораторийн эрхлэгч нь хэмжлийн эргэлзээ тооцсон сорилтын үр дүнг хянаж, баталгаажуулна.

- 4.7. Лабораторийн шинжээч нь хэмжлийн эргэлзээ тооцсон тухай бүртгэлийг хөтөлж, тухайн жилийн бүртгэлүүдтэй хамт хадгална. /Маягт 01/
- 4.8. Хэмжлийн эргэлзээг итгэмжлэлийн хүрээний тодорхойлолтонд багтсан дараах материал, түүхий эдэд тооцно.

Үүнд:

Хүснэгт №1

Тоосго					
Д/Д	Тодорхойлох үзүүлэлтүүд	А төрлийн эргэлзээ	Б төрлийн эргэлзээ	Нийлмэл эргэлзээ	Өргөтгөсөн эргэлзээ
1	Хуурай үеийн жин	+	+	+	+
2	Хэмжээ	+			
3	Шахалтын бат бэх	+	+	+	+
4	Эзлэхүүн жин	+			
5	Булангийн эмтрэл	+			

Хүснэгт №2

Бетон сорьц					
Д/Д	Тодорхойлох үзүүлэлтүүд	А төрлийн эргэлзээ	Б төрлийн эргэлзээ	Нийлмэл эргэлзээ	Өргөтгөсөн эргэлзээ
1	Шахалтын бат бэх	+	+	+	+

Хүснэгт №3

Хөөсөн полистрол хавтан					
Д/Д	Тодорхойлох үзүүлэлтүүд	А төрлийн эргэлзээ	Б төрлийн эргэлзээ	Нийлмэл эргэлзээ	Өргөтгөсөн эргэлзээ
1	Хуурай үеийн дундаж жин	+	+	+	+
2	Дундаж эзлэхүүн	+	+	+	+
3	Дундаж ус шингээсэн жин	+	+	+	+

Хүснэгт №4

Хөнгөн бетон гулдмай					
Д/Д	Тодорхойлох үзүүлэлтүүд	А төрлийн эргэлзээ	Б төрлийн эргэлзээ	Нийлмэл эргэлзээ	Өргөтгөсөн эргэлзээ
1	Хуурай үеийн дундаж жин	+	+	+	+

2	Чийгтэй үеийн дундаж жин	+	+	+	+
3	Шахалтын бат бэх	+	+	+	+

Хүснэгт №5

Явган зам талбайн хавтан					
Д/Д	Тодорхойлох үзүүлэлтүүд	А төрлийн эргэлзээ	Б төрлийн эргэлзээ	Нийлмэл эргэлзээ	Өргөтгөсөн эргэлзээ
1	Шахалтын бат бэх	+	+	+	+
2	Булангийн эмтрэл	+			

Хүснэгт №6

Дайрга /хайрга/					
Д/Д	Тодорхойлох үзүүлэлтүүд	А төрлийн эргэлзээ	Б төрлийн эргэлзээ	Нийлмэл эргэлзээ	Өргөтгөсөн эргэлзээ
1	Нягт	+	+	+	+
2	Ширхэгийн дундаж нягт	+	+	+	+
3	Асгаасны нягт	+	+	+	+

Хүснэгт №7

Элс					
Д/Д	Тодорхойлох үзүүлэлтүүд	А төрлийн эргэлзээ	Б төрлийн эргэлзээ	Нийлмэл эргэлзээ	Өргөтгөсөн эргэлзээ
1	Нягт	+	+	+	+
2	Элсэнд агуулагдах хайрга	+	+	+	+
3	Асгаасны нягт	+	+	+	+

5. Хэмжлийн эргэлзээг тооцоолох алхам:

Алхам 1: Тухайн түүхий эдийн дээжинд батлагдсан стандартын дагуу хэмжилтийг хийж, хэмжилтийн арифметик дундаж утгыг олно.

Алхам 2: Олсон арифметик дундаж утга нь тухайн хэмжилтүүдийн аль утгатай ойролцоо болохыг тодорхойлохын тулд стандарт хазайлтыг тодорхойлно.

Алхам 3: Тухайн хэмжилт нь А эсвэл Б төрлийн стандарт эргэлзээний аль нь болох, эсвэл аль аль нь тухайн хэмжилтэнд байгаа эсэхийг тодорхойлно.

Алхам 4: Чөлөөний зэргийг $n-1$ зарчмаар олно.

Алхам 5: Дээрх алхамуудын үр дүнд нийлмэл эргэлзээг олох боломжтой болох ба нийлмэл эргэлзээний олсон утгыг ашиглаж өргөтгөсөн эргэлзээг олно.

Алхам 6: Хэмжилтийн үр дүнг бичихдээ хэмжлийн эргэлзээг тооцож олсон өргөтгөсөн эргэлзээний утгын хамт бичвэрийн зөв хэлбэрийн дагуу илэрхийлнэ.

6. Хэмжлийн эргэлзээг хэрхэн илэрхийлэх

- 6.1. Шалгалт тохируулгын гэрчилгээн дээрх U өргөтгөсөн эргэлзээ нь ойролцоогоор 95%-ын хамруулах магадлалд тохирсон хэвийн тархалтын хамруулах коэффициент $k=2$ -оор үржүүлсэн стандарт эргэлзээгээр тогтоогдсон байдаг.
- 6.2. Хэмжлийн үр дүнгийн бичвэрийг дараах байдлаар бичих нь зүйтэй.

Д/Д	Үр дүнг бичих дүрмүүд	Бичвэрийн зөв хэлбэр	Бичвэрийн буруу хэлбэр
1	Хэмжлийн үр дүнг эргэлзээний утгатай өгөх	$m=(40.12\pm0.04)$ г	$m=40.12$ г
2	Хэмжлийн эргэлзээг хоёр утгат цифрээр илэрхийлэх	$m=(40.1\pm0.22)$ г	$m=(40.1\pm0.218)$ г
3	Эхний утгат цифр нэг бол арын орны цифрийг заавал үлдээнэ	$m=(40.1\pm0.12)$ г	$m=(40.1\pm0.1)$ г
4	Хэмжлийн үр дүн ба эргэлзээний сүүлийн цифр ижил оронд хадгалагдана.	$L=(12.4\pm0.4)$ см	$L=(12.385\pm0.4)$ см
5	Үр дүн 10^n хэлбэртэй бол эргэлзээний зэргийн илтгэгч ижил байна.	$R=(1.2\pm0.04)\cdot 10^5$ Ом	$R=(1.2\cdot 10^5\pm4\cdot 10^3)$ Ом
6	Үр дүн ба эргэлзээ ижил нэгжтэй байна.	$I=(0.24\pm0.04)$ А	$I=0.24\text{А}\pm0.04\text{мА}$

7. Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах

- 7.1. Энэхүү журамд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа ГХБХБГ-ын даргын тушаалаар шийдвэрлэнэ.
- 7.2. Журамд орсон нэмэлт, өөрчлөлт оруулахыг лабораторийн эрхлэгч бүртгэнэ.
/Маягт 02/